

**Статистикийн тэргүүний мэдээлэгч байгууллага  
шалгаруулах журам**

**Нэг. Зорилго**

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Статистикийн албан ёсны мэдээ тайлангийн үнэн бодит байдлыг дээшлүүлэн, мэдээ тайланг тогтоосон хугацаанд нь үнэн зөв, шуурхай мэдээлдэг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулан, мэдээлэгчтэй хамтран ажиллах ажиллагааг сайжруулахад оршино.
- 1.2 Статистикийн тэргүүний мэдээлэгч байгууллагыг шалгаруулахдаа энэ журмын 2.1-д заасан болзлыг гол шалгуур болгоно.
- 1.3 Энэ журам нь Үндэсний статистикийн албанаас шалгаруулах статистикийн тэргүүний мэдээлэгч байгууллагад хамаарна.

**Хоёр. Статистикийн тэргүүний мэдээлэгч байгууллагыг  
шалгаруулах болзол**

- 2.1. Статистикийн тэргүүний мэдээлэгч байгууллага нь дараах болзлыг хангасан байна Үүнд:
  - 2.1.1 Статистикийн мэдээлэгчийн эрх, үүргийн талаарх “Статистикийн тухай” Монгол улсын хуулийн 9 дүгээр зүйлийг бүрэн хэрэгжүүлсэн байх;
  - 2.1.2 Статистикийн албан ёсны мэдээ тайланг анхан шатны бүртгэлд тулгуурлан тогтоосон хугацаанд нь гаргаж хэвшсэн байх;
  - 2.1.3. Анхан шатны бүртгэл, тайлан тэнцэл, мэдээллийн хамралт, үнэн зөв байдлыг хангаж, статистик мэдээллийг шуурхай гаргаж мэдээлсэн байх, түүнчлэн энэ чиглэлээр тодорхой шинэлэг ажлуудыг санаачлан хийж, бодитой үр дүнд хүрсэн байх;
  - 2.1.4. Жил бүрийн санхүүгийн тайлан тэнцлээ аудит болон татварын хяналт шалгалтаар баталгаажуулсан байх;
  - 2.1.5 Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь өөрчлөгдсөн тохиолдолд статистикийн байгууллагад тухай бүрт шуурхай мэдээлж, бизнес регистрийн санд нөхөлт, баяжилт, өөрчлөлтийг хийлгүүлсэн байх;
  - 2.1.6 Албан ёсны статистикийг 2006-2010 онд хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон статистикийн албанаас зохион байгуулсан тооллого, түүвэр судалгаанд идэвхитэй бүрэн хамрагдаж, үнэн зөв мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгсөн байх;
  - 2.1.7 Өөрийн салбар болон охин компанитай бол тайлан мэдээг үнэн зөв, хамралт сайтай гаргаж өгсөн байна.

2.2. Аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсүүд Засаг даргын Тамгын газрын санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс болон бусад газар, хэлтсүүдийг оролцуулсан ажлын хэсэг байгуулан шалгаруулалтыг явуулна.

2.3. Энэхүү журмын 2.1 –д заасан болзлыг хангасан аж ахуйн нэгж байгууллагуудаас аймгийн статистикийн хэлтсүүд тус бүр 1, нийслэлийн статистикийн газар 5 аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулж, тухайн байгууллага дээр очиж ажил байдалтай танилцаж, үнэлгээ өгч, холбогдох материалыг жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор Үндэсний статистикийн газарт ирүүлнэ.

2.4. ҮСГ нь Статистикийн тэргүүний мэдээлэгчээр шалгаруулах аж ахуйн нэгж, байгууллагын материалыг хүлээн авч, журамд заасан болзлыг хангасан байдлыг мэдээллийн бусад эх үүсвэртэй тулган эцэслэн шалгана.

2.5. Статистикийн тэргүүний мэдээлэгч байгууллагын шалгаруулалтын дүнг ҮСГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

### **Гурав. Статистикийн тэргүүний мэдээлэгч байгууллагыг шагнаж, урамшуулах**

3.1. Статистикийн тэргүүний мэдээлэгч 5 хүртэл байгууллагыг “Статистикийн тэргүүний мэдээлэгч байгууллага”-аар жил бүр шалгаруулна.

3.2. “Статистикийн тэргүүний мэдээлэгч байгууллага”-ыг шалгаруулж дараах хэлбэрээр урамшуулна. Үүнд:

3.1.1. Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь анх удаа шалгарч байгаа бол “Гэрчилгээ”, дурсгалын зүйлээр;

3.1.2. Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь 2 дахь жилдээ шалгарч байгаа бол “Батламж”, дурсгалын зүйлээр;

3.1.3. Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь 3 ба түүнээс дээш жил шалгарч байгаа бол “Өргөмжлөл”, дурсгалын зүйлээр;

3.3. “Статистикийн тэргүүний мэдээлэгч байгууллага”-аар шалгарсан байгууллагын удирдлага, статистикийн мэдээлэл хариуцсан ажилтныг Үндэсний статистикийн салбарын шагналаар шагнаж урамшуулна;

3.4. “Статистикийн тэргүүний мэдээлэгч байгууллага”-аар шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагад дараах эрхийг эдлүүлнэ. Үүнд:

3.4.1. Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 6 дугаар бүлгийн 22 дугаар зүйлийн 7 дугаар заалтанд тусгагдсан мэдээллийг үнэ төлбөргүй авах;

3.4.2. Үндэсний статистикийн салбарын түншлэгч, түшиц газар болгон хамтарч ажиллах;

3.4.3. Статистикийн тэргүүний мэдээлэгч аж ахуйн нэгж, байгууллагын ажлын арга туршлагыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд хамтран зарлаж сурталчилна.